



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 20/02

Хужирт сум

Сумын 2024 оны төсөвт тодотгол хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 29/01 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн “Сумын 2024 оны төсөв батлах тухай” 16/04 дүгээр тогтоолд дараах өөрчлөлтүүдийг оруулсугай. Үүнд:

Нэг. Тогтоолын 1.1.1-д заасан үйл ажиллагааны орлогын дүнг 202,219.8 (хоёр зуун хоёр сая хоёр зуун арван есөн мянга найман зуу) мянган төгрөгөөр нэмэгдүүлж 232,000.0 (хоёр зуун гучин хоёр сая) мянган төгрөг, 1.1.10-т заасан татварын буцаан олголтын дүнг 22,361.9 (хорин хоёр сая гурван зуун жаран нэгэн мянга есөн зуу) мянган төгрөгөөр бууруулж 36,442.3 (гучин зургаан сая дөрвөн зуун дөчин хоёр мянга гурван зуу) мянган төгрөг, татварын бус орлого 21,159.2 (хорин нэгэн сая нэг зуун тавин есөн мянга хоёр зуу) мянган төгрөг болгон өөрчлөн татварын орлогын нийт хэмжээг 1,676,558.5 (нэг тэрбум зургаан зуун далан зургаан сая таван зуун тавин найман мянга таван зуу) мянган төгрөг болгон өөрчлөн баталсугай.

Хоёр. Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 4,500.0 (дөрвөн сая таван зуун мянга) мянган төгрөг, Засаг даргын Тамгын газарт 87,566.6 (наян долоон сая таван зуун жаран зургаан мянга зургаан зуу) мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд 40,392.5 (дөчин сая гурван зуун ерэн хоёр мянга таван зуу) мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсүгэй.

Гурав. Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 314,816.6 (гурван зуун арван дөрвөн сая найман зуун арван зургаан мянга найман зуу) мянган төгрөгөөр бууруулж 937,410.7 (есөн зуун гучин долоон сая дөрвөн зуун арван мянга долоон зуу) мянган төгрөг болгон өөрчлөн баталсугай.

Дөрөв. Тогтоолын 6.4-т заасан урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 222,694.0 (хоёр зуун хорин хоёр сая зургаан зуун ерэн дөрвөн мянга) мянган

D:/2024/ITKH togtool/  
622401030

төгрөгөөр нэмэгдүүлж, 653,818.5 (зургаан зуун тавин гурван сая найман зуун арван найман мянга таван зуу) мянган төгрөг болгон өөрчилсүгэй.

Тав. Сумын 2024 оны төсвийн жилд ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагуудын төсвийг дор дурдсанаар өөрчлөн баталсугай.

/Мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт дүнгээр
1	ИТХурал	285,733.5
2	ЗДТГазар	1,628,815.4
3	Орон нутгийн хөгжлийн сан	704,512.1

Зургаа. Сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 10,607.5 (арван сая зургаан зуун долоон мянга таван зуу) мянган төгрөгөөр нэмэгдүүлж 292,337.4 (хоёр зуун ерэн хоёр сая гурван зуун гучин долоон мянга дөрвөн зуу) мянган төгрөг, оны эхний үлдэгдэл 291,782.2 (хоёр зуун ерэн нэгэн сая долоон зуун наян хоёр мянга хоёр зуу) мянган төгрөг, малын албан татвар 80,000.0 (наян сая), оны эхний үлдэгдлээс санхүүжих 40,392.5 (дөчин сая гурван зуун ерэн хоёр мянга таван зуу), нийт 704,512.1 (долоон зуун дөрвөн сая таван зуун арван хоёр мянган нэг зуу) болгон өөрчлөн орлого зарлагыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Долоо. Сумын төсөвт байгууллагын орлого зарлагын өөрчлөлтийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.


Найм. Тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ"-г 2024 онд санхүүжихээр төлөвлөгдсөн болон тодотголоор нэмэгдэх санхүүжилтээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг энэхүү тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсугай.

Ес. Тогтоолын зургаа дугаар хавсралтаар батлагдсан "Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал"-ын 2024 онд санхүүжихээр төлөвлөгдсөн болон тодотголоор нэмэгдэх санхүүжилтээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг энэхүү тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.

Арав. Сумын орон нутгийн байгууллагуудын албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар тооцон олгосугай.


Арван нэг. 2024 оны батлагдсан төсвийн сар улирлын хуваарьт өөрчлөлт оруулан батлан мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга (Д.Батбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ОЮУНГЭРЭЛ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 02 дүгээр сарын 02 ны өдрийн  
20/02 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралт



ОНХСан, СХСан, ЭХСангийн зарлага санхүүжилт

мян/төг

Үзүүлэлтүүд	ОНХСан	СХСан	ЭХСан	Бүгд дүн
Мөн/хөр-н 2023.01.01-ний үлдэгдэл	291,782.2	46,644.2	38,527.0	376,953.4
ОНХСангийн санхүүжилт	292,337.4			292,337.4
Үйл ажиллагааны орлого		76,447.8		76,447.8
Малын албан татвар	80,000.0			80,000.0
Давсан орлого	40,392.5			40,392.5
Орлогын дүн	704,512.1	123,092.0	38,527.0	866,131.1
Эргэж төлөгдөх зээл		123,092.0		123,092.0
Бичиг хэрэг				0.0
Тээвэр шатахуун				0.0
Бусад хөрөнгө	704,512.1			704,512.1
Бараа үйлчилгээний бусад зардал			38,527.0	38,527.0
Зардлын дүн	704,512.1	123,092.0	38,527.0	866,131.1

--oOo--







Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн  
2024 дүгээр тогтоолын 03 дугаар хавсралт



СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2024 ОНЫ  
ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(мянган төгрөг)


д/д	Төсөл арга хэмжээний нэр	Хамрах салбар	Эхлэх, дуусах хугацаа	Нийт төсөвт өртөг	2024 онд санхүүжүүлэх дүн
1	2	3	4	5	6
1. Шилжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ					
1	Цэцэрлэгт хүрээлэн байгуулах	Нийтийн аж ахуй	2023-2024	116,000.0	76,032.5
2	Сумын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах	Нийтийн аж ахуй	2022-2024	79,200.0	31,680.0
3	2-р цэцэрлэгийн хүнсний агуулах барих	СӨББ	2023-2024	20,000.0	7,855.6
4	Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж	ЭМБ	2023-2024	45,000.0	41,900.0
Дүн				260,200.0	157,468.1
2. Малын албан татвараар шинээр эхлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ					
1	Ойн хортон шавжтай тэмцэх	МАА	2024	30,000.0	30,000.0
2	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх	МАА	2024	20,000.0	20,000.0
3	Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан	МАА	2024	22,000.0	22,000.0
4	Бод малын тарилгын хашаа	МАА	2024	20,000.0	20,000.0
5	Дүн			92,000.0	92,000.0
3. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ					
1	1-р багийн төвийн засвар	Нийтийн аж ахуй	2024	100,000.0	100,000.0
2	Наадмын талбайн тохижилт	Нийтийн аж ахуй	2024	50,000.0	50,000.0
4	Гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засварлах	Нийтийн аж ахуй	2024	50,000.0	50,000.0
5	Соёмбот талбайн тохижилт	Нийтийн аж ахуй	2024	10,000.0	10,000.0
6	Соёлын төвийн урлагын хувцас, техник шинэчлэх	Соёл урлаг	2024	100,000.0	100,000.0
7	Бизнес хөгжлийн төвийн засвар	Нийтийн аж ахуй	2024	37,044.0	37,044.0
8	Хог тээврийн автомашин	Нийтийн аж ахуй	2024	86,000.0	86,000.0

9	Смарт худгийн тоног төхөөрөмж	Нийтийн аж ахуй	2024	22,000.0	22,000.0
	Дүн			455,044.0	455,044.0
	Нийт зардлын дүн			807,244.0	704,512.1
1	2023 оны үлдэгдэл				279,782.2
2	Малын албан татварын 2023 оны үлдэгдэл				12,000.0
3	Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт				292,337.4
4	Малын албан татвар				80,000.0
5	Орон нутгийн төсөв				40,392.5
	Нийт санхүүжилтийн дүн				704,512.1

--oOo--



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн  
09/02 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралт



**БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ**

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Хамрах салбар	Эхлэх, дуусах хугацаа	Нийт төсөвт өртөг	2024 онд санхүүжүүлэх дүн
1	2	3	4	5	6
<b>1. Шилжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ</b>					
1	Шувууны амьдрах орчныг сайжруулж шувууны суудал байрлуулах	Байгаль орчин	2023-2024	10,000.0	5,000.0
2	Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, урамшуулах, сургалт сурталчилгаа зохион байгуулах	Байгаль орчин	2023-2024	10,000.0	4,227.5
3	Шинээр төвлөрсөн хог хаягдлын цэг байгуулах, хашаажуулах, камержуулах	Байгаль орчин	2023-2024	25,000.0	25,000.0
<b>Дүн</b>				<b>45,000.0</b>	<b>34,227.5</b>
<b>2. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ</b>					
1	Нэн ховор, ховор амьтадад биотехникийн арга хэмжээ авах	Байгаль орчин	2024	4,000.0	4,000.0
2	Нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдал цэвэрлэх	Байгаль орчин	2024	4,000.0	4,000.0
3	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Байгаль орчин	2024	17,249.6	17,249.6
4	Ойн хортон шавжийн судалгаа хийх, Ой хээрийн түймэр, хууль бус ан агнуур, мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Байгаль орчин	2024	7,800.0	7,800.0
5	Хууль бус мод бэлтгэл, ан агнуураас урьдчилан сэргийлэх хяналт тавих томилолтын зардал	Байгаль орчин	2024	2,200.0	2,200.0
6	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих ажлыг зохион байгуулахад шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах	Байгаль орчин	2024	4,500.0	4,500.0
<b>Дүн</b>				<b>39,749.6</b>	<b>39,749.6</b>
<b>Нийт дүн</b>				<b>84,749.6</b>	<b>73,977.1</b>